

Аудитын код: САГ-2018/95/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

САГ-ын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Нямдаваа

Утас: 260512 Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

Гүйцэтгэгч: Стандарт дүгнэлт аудит ХХК

Утас: 70111721



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргагүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
2.9.1	Байгууллагын үйл ажиллагаа.....	8
2.9.2	Орлогын албан татвар.....	9
2.9.3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг.....	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.12	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Байгууллагын үйл ажиллагаа.....	12
3.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг.....	13
4	Аудит хийгдсэн Санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийгдсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4	Аудит хийгдсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5	Аудит хийгдсэн Зардлын гүйцэтгэлийн тайлан.....	21



1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/688
танай _____-ны № _____-т

ТАВАН ТОЛГОЙН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСЛИЙН НЭГЖИЙН
ЗАХИРАЛ Д.БАТБИЛЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0315SAG17.Docx

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгж нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0315SAG17.Docx



Аудитын тайлан

1.1 Оршил

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн Захирал Д.Батбилэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан дансны ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 д заасны дагуу Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус төслийн нэгж санхүүгийн тайлан, тодруулгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-наас 2017 оны 03 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлэв.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгж 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 5 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид төлөвлөсөн бодлого, журмын дагуу Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрчим Хүчний Сайд 2013 оны 03 сарын 19-ний 36 дугаар тушаалаар Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийг байгуулах шийдвэр гаргажээ.


Монгол Улсын Засгийн Газар, Засгийн Газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, Монгол Улсын төвийн бүсийн болон өмнийн говийн стратегийн орд газруудын эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих тухай Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013 оны 71 дүгээр тогтоол, Төсөл санхүүжүүлэх тухай 2013 оны 80 дугаар тогтоол, Төрийн өмчийн оролцоотой компани байгуулах тухай 2013 оны 129 дүгээр тогтоол, Тавантолгойн цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх тухай 2013 оны 261 дүгээр тогтоолуудыг тус тус баталсан байна.

Эрчим хүчний яамны “Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгж” нь төслийн хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Хөгжлийн банк зэрэг байгууллага төсөлд зохих үүрэгтэй оролцохоор төлөвлөжээ.

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-А-1 маягтаар баталгаажуулсан болно.

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн удирдлага дараах хууль болон, СТОУС, НББОУС, УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль



- Эрчим хүчний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Байгаль орчны тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын багц хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд тус төслийн нэгж өөрийн байгууллагын хариуцлагын хэлбэр, үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод хяналттай холбоотой

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгж нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг ТАБ-СТА-В-2 маягтын дагуу үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “ACOLOSE” програм хангамж ашиглажээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг (ТАБ-СТА-В-5-1, ТАБ-СТА-В-5-2) маягтад нэгтгэж, баримтжуулав.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг (ТАБ-СТА-А-5-3) маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, түүнийг сорих 8 горим сорил боловсруулав.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгов. (ТАБ-СТА-А-4)

Нийт зарлагыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус төслийн нэгжийн үйл ажиллагаа жигдрээгүй тул нийт зардал эдийн засгийн хувьд чухал үзүүлэлт гэдэгтэй холбоотой юм.

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлан дах нийт зардал 5,999.4 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 60.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэлийн үнэлгээтэй холбоотой юм.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 8 эрсдэлтэй асуудалд 8 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. (ТАБ-СТА-В-3.1 - ТАБ-СТА-В-3.7)

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Аудитын явцад залруулга гараагүй.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.



(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2		
2	Төлбөрийн акт тогтоосон	1	4.1	
3	Албан шаардлага өгсөн			
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн			
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн			
	Дүн	3	4.1	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4 маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:


1.9.1 Байгууллагын үйл ажиллагаа

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн удирдлага Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж төсвийн байгууллага хэлбэрээр санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа боловч тус төслийн нэгжийн хариуцлагын хэлбэрийг тодорхой болгож баталгаажуулаагүй байна.

Энэ нь байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн эрхлэн явуулахад дараах хүндрэл учруулж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, тайлагнах, үйл ажиллагааны орлого, зарлагыг батлах, гүйцэтгэлийг тооцох, хяналт тавих зэрэг үйл ажиллагааг төсвийн байгууллага эсвэл төрийн өмчит аж ахуйн нэгжийн аль жишгээр нь эрхлэн явуулах нь тодорхойгүйгээс төсвийн өмнө хүлээх үүргийн биелэлтийг тооцох боломжгүй болгосон;
- санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн төрийн өөрийн хөрөнгийн хэмжээг улсын бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулаагүй, улсын бүртгэлийн гэрчилгээ аваагүй, төслийн нэгжийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон өмч, хөрөнгө, хуримтлагдсан үр дүн цаашид хаана хэрхэн бүртгэгдэх, хэн хариуцах нь тодорхойгүй байдалтай байна.

Шийдвэрлэсэн нь:



Байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан эрх зүйн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүртгүүлэх зөвлөмж хүргүүлэх

1.9.2 Орлогын албан татвар

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад Хөгжлийн банкинд 2017 онд хадгалуулсан мөнгөний дансны үлдэгдэлд тооцож, олгосон 40.9 сая төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогод 4.1 сая төгрөгийн орлогын албан татвар ногдуулж, төсөвт төвлөрүүлээгүй нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 17 дугаар зүйлийн 17.2.6, 21.7-д 21 дүгээр зүйлийн 21.1-д "Албан татвар төлөгч нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар гаргасан улирал, жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Хадгаламжийн хүүгийн орлогоос суутгаагүй татварыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

1.9.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Төслийн нэгжийн хариуцлагын хэлбэр тодорхойгүйгээс өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь:

Өөрийн байгууллагын хариуцлагын хэлбэр, үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, мөрдөх зөвлөмж өгөх


1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй

1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга баталсан Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 1,640.3 сая, төслийн бэлтгэл ажлын зардлыг 16,422.2 сая төгрөгөөр тус тус хянаж, баталсан байна.

Гүйцэтгэлээр 2017 онд үйл ажиллагааны зардалд 746.5 сая, төслийн бэлтгэл ажлын зардалд 8,729.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 45.5 хувь буюу 893.8 сая, төслийн бэлтгэл ажлын зардлыг 53.1 хувь буюу 7,692.4 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Тус төслийн нэгж төлөвлөсөн зардлыг их хэмжээгээр хэмнэсэн нь төслийн үйл ажиллагаа жигдрээгүй, төлөвлөсөн ажил, арга хэмжээг тайлант хугацаанд хэрэгжүүлж, чадаагүйтэй холбоотой байна.

Төслийн бэлтгэл ажлын зардлын 94.1 хувь буюу 8,216.7 сая төгрөг нь Хөгжлийн банкинд төлсөн зээлийн хүүгийн зардал байна.

1.12 Шилэн дансны мэдээлэл

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгж Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн (<http://www.tppp.mn/>) цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх тухай зөвлөмжийг байгууллагын хариуцлагын хэлбэр тодорхойгүйгээс бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг менежментийн захидалд тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг зөрчилгүй гэж үзсэн.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.



2.1 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Илрүүлэлт

Таван толгойн цахилгаан станц төслийн нэгжийн удирдлага Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж төсвийн байгууллага хэлбэрээр санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа боловч тус төслийн нэгжийн хариуцлагын хэлбэрийг тодорхой болгож баталгаажуулаагүй байна.

Энэ нь байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн эрхлэн явуулахад хүндрэлтэй байна.

Эрсдэл

Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаанд хяналт тавих боломжгүй болж, дотоод хяналт сулрах

Төсвийн өмнө хүлээх үүргийн биелэлт

Үнэн зөв байдал батламж мэдэгдэл зөрчигдөх,

Зөвлөмж

Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогт тохирох хариуцлагын хэлбэрийг сонгож, баталгаажуулах,

Байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

2.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Илрүүлэлт

Төслийн нэгжийн хариуцлагын хэлбэр тодорхойгүйгээс өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Эрсдэл

Үнэн зөв байдал, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл зөрчигдөх,

Зөвлөмж

Өөрийн байгууллагын хариуцлагын хэлбэр, үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн боловсруулж, баталгаажуулан үйл ажиллагаандаа мөрдөх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

3.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2017-01-01	2017-12-31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33 626 382 376,25	23 641 657 884,35
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	19 007 847 955,06	9 005 770 496,46
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	17 763 082 955,06	8 641 700 996,46
9	Төгрөг	16 898 491,05	34 389 731,38
12	Арилжааны банкин дахь харилцах	16 898 491,05	34 389 731,38
16	Гадаад валютаар	17 746 184 464,01	8 607 311 265,08
19	Арилжааны банкин дахь харилцах	17 746 184 464,01	8 607 311 265,08
21	Хадгаламж	1 244 765 000,00	364 069 500,00
27	АВЛАГА	3 052 500,00	2 720 000,00
34	Бусад авлага	3 052 500,00	2 720 000,00
35	Байгууллагаас авах авлага	3 052 500,00	2 720 000,00
48	УРЬДЧИЛГАА	14 606 154 245,53	14 628 344 993,41
54	Урьдчилж гарсан зардал	14 606 154 245,53	14 628 344 993,41
60	БАРАА МАТЕРИАЛ	9 327 675,66	4 822 394,48
66	Хангамжийн материал	9 327 675,66	4 822 394,48
67	Бичиг хэргийн материал	1 202 800,00	3 076 570,00
68	Аж ахуйн материал	7 920 141,00	1 260 700,00
69	Сэлбэг хэрэгсэл	-	15 000,00
70	Түлш шатах тослох материал	204 734,66	470 124,48
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	405 349 790,71	312 850 883,91
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	405 349 790,71	312 850 883,91
108	Биет хөрөнгө	403 803 007,69	311 986 925,65
111	Авто тээврийн хэрэгсэл	395 400 000,00	395 400 000,00
112	Хуримтлагдсан элэгдэл	(94 666 666,80)	(160 566 666,84)
113	Машин, тоног төхөөрөмж	77 044 820,00	77 044 820,00
114	Хуримтлагдсан элэгдэл	(49 987 990,08)	(64 813 077,60)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	110 909 943,00	110 909 943,00
116	Хуримтлагдсан элэгдэл	(34 897 098,43)	(45 988 092,91)
126	Биет бус хөрөнгө	1 546 783,02	863 958,26
127	Програм хангамж	4 002 117,00	4 002 117,00
128	Хасагдуулга	(2 455 333,98)	(3 138 158,74)
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34 031 732 166,96	23 954 508 768,26
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	44 221 918 049,63	36 652 341 847,65
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7 336 416 697,60	691 374 558,02
164	Өглөг	7 336 416 697,60	691 374 558,02
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	628 710,00	0,00
169	Зээлийн хүүгийн өглөг	6 696 127 304,24	691 374 558,02
170	Бусад өглөг	639 660 683,22	0,00
171	Байгууллагад төлөх өглөг	639 660 683,22	0,00

183	УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	36 885 501 352,03	35 960 967 289,63
193	Урт хугацаат зээл	36 885 501 352,03	35 960 967 289,63
202	Гадаад валют	36 885 501 352,03	35 960 967 289,63
206	Төслийн зээл	36 885 501 352,03	35 960 967 289,63
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	(10 190 185 882,67)	(12 697 833 079,39)
215	Засгийн газрын хувь оролцоо	(10 190 185 882,67)	(12 697 833 079,39)
223	Хуримтлагдсан үр дүн	(10 190 185 882,67)	(12 697 833 079,39)
224	Өмнөх үеийн үр дүн	(10 190 185 882,67)	(10 190 185 882,67)
225	Тайлант үеийн үр дүн	-	(2 507 647 196,72)
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	34 031 732 166,96	23 954 508 768,26

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)


№	ҮЗҮҮЛЭЛТ	2017-01-01	2017-12-31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	97 900 807,81	40 934 934,37
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97 900 807,81	40 934 934,37
77	Нийтлэг татварын бус орлого	97 900 807,81	40 934 934,37
78	Хүүгийн орлого	97 461 936,45	40 878 478,15
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	438 871,36	56 456,22
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	164 684,00	-
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	274 187,36	56 456,22
146	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1 158 023 062,69	3 108 508 793,12
147	УРСГАЛ ЗАРДАЛ	1 158 023 062,69	3 108 508 793,12
148	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 158 023 062,69	3 108 508 793,12
149	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	609 563 059,98	440 336 501,26
150	Цалин	574 013 059,98	424 976 501,26
153	Урамшуулал	22 750 000,00	-
154	Гэрээтийн цалин	12 800 000,00	15 360 000,00
156	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67 431 306,56	48 364 107,05
157	Тэтгэврийн даатгалын шимтгэл	42 927 122,42	31 030 784,89
158	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4 905 956,84	4 432 969,27
159	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6 132 446,06	3 525 255,41
160	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1 200 889,22	824 354,32
161	Эрүүл мэндийн даатгалын хураамж	12 264 892,02	8 550 743,16
163	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119 336 059,58	120 609 067,38
164	Гэрэл цахилгааны зардал	1 810 240,85	1 851 316,10
165	Түлш, халаалтын зардал	-	2 221 938,20
166	Цэвэр, бохир усны зардал	-	913 273,08
167	Байрны түрээс	117 525 818,73	115 622 540,00
169	Хангамж, бараа материалын зардал	39 342 837,16	40 015 072,05
170	Бичиг хэргийн материал	6 411 681,00	4 221 688,00
171	Тээвэр, шатахууны зардал	14 495 970,12	13 716 321,40
172	Шуудан холбоо интернетийн төлбөр	12 322 810,04	9 895 133,45
173	Ном, хэвлэлийн зардал	750 000,00	-
175	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	4 630 976,00	7 883 576,00
176	Аж ахуйн материал худалдан авах зардал	731 400,00	3 557 163,20
177	Бараа материал актасны зардал	-	741 190,00
184	Эд хогшил, урсгал засварын зардал	15 016 680,00	12 991 350,00
188	Урсгал засвар	15 016 680,00	12 991 350,00
189	Томилолт, зочны зардал	131 452 308,00	68 682 050,00
190	Гадаад томилолтын зардал	75 385 292,00	64 525 891,00
191	Дотоод томилолтын зардал	34 525 730,00	11 590 380,00

192	Зочин төлөөлөгч хүлээн авах	21 541 286,00	2 565 779,00
193	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	67 486 308,38	19 726 466,87
194	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21 371 200,00	5 591 000,00
195	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	8 000 000,00	-
196	Даатгалын үйлчилгээний төлбөр	5 356 560,00	8 965 050,00
197	Тээврийн хэрэгслийн татвар	326 600,00	529 414,00
198	Тээврийн хэрэгслийн оношилгоо	27 500,00	55 000,00
199	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	32 282 500,00	3 186 000,00
201	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	121 948,38	1 400 002,87
208	Бараа үйлчилгээний бусад зардал	108 394 503,03	2 357 784 178,51
209	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2 229 013 725,71
210	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	61 297 297,82	36 271 546,00
211	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47 097 205,21	92 498 906,80
267	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(1 060 122 254,88)	(3 067 573 858,75)
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	6 094 920 758,24	3 450 829 375,11
269	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	6 094 920 758,24	3 450 829 375,11
275	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	10 524 376 261,21	2 890 902 713,08
276	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	63 537 565,11	-
279	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	10 460 838 696,10	2 890 902 713,08
286	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(4 429 455 502,97)	559 926 662,03

3.3 Аудит хийгдсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2017-01-01	2017-12-31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	97 747 820,45	41 210 978,15
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97 747 820,45	41 210 978,15
78	Нийтлэг татварын бус орлого	97 747 820,45	41 210 978,15
80	Хүүгийн орлого	97 461 936,45	40 878 478,15
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	285 884,00	332 500,00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	332 500,00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	285 884,00	-
146	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1 120 925 307,22	9 530 040 671,56
147	УРСГАЛ ЗАРДАЛ	1 120 925 307,22	9 530 040 671,56
148	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 120 925 307,22	9 530 040 671,56
149	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	612 308 458,83	440 965 211,40
150	Үндсэн цалин	599 508 458,83	425 605 211,40
154	Гэрээт ажлын хөлс	12 800 000,00	15 360 000,00
156	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	64 057 197,57	48 364 107,05
157	Тэтгэврийн даатгалын шимтгэл	40 779 962,09	31 030 784,89
158	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4 660 567,09	4 432 969,27
159	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5 825 708,87	3 525 255,41
160	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1 139 541,78	824 354,32
161	Эрүүл мэндийн даатгалын хураамж	11 651 417,74	8 550 743,16
163	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	119 336 059,58	120 609 067,38
164	Гэрэл цахилгааны зардал	1 810 240,85	1 851 316,10
165	Түлш, халаалтын зардал	-	2 221 938,20
166	Цэвэр, бохир усны зардал	-	913 273,08
167	Байрны түрээс	117 525 818,73	115 622 540,00
169	Хангамж, бараа материалын зардал	40 363 045,04	35 469 331,45
170	Бичиг хэрэг	7 771 401,00	6 093 958,00
171	Тээвэр, шатахуун	14 169 200,00	14 025 855,00
172	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12 322 810,04	9 895 133,45
173	Ном, хэвлэл	750 000,00	-
175	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5 349 634,00	2 166 025,00
176	Аж ахуйн материал худалдан авах зардал		3 288 360,00
184	Эд хогшил, урсгал засварын зардал	14 335 880,00	12 988 983,20
188	Урсгал засвар	14 335 880,00	12 988 983,20
189	Томилолт, зочны зардал	131 452 310,00	68 673 420,00



190	Гадаад албан томилолт	75 385 292,00	54 525 891,00
191	Дотоод албан томилолт	34 525 730,00	11 627 780,00
192	Зочин төлөөлөгч хүлээн авах	21 541 288,00	2 519 749,00
193	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77 775 058,38	19 726 466,87
194	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	28 607 450,00	5 591 000,00
195	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8 000 000,00	-
195	Даатгалын үйлчилгээ	5 356 560,00	8 965 050,00
197	Тээврийн хэрэгслийн татвар	326 600,00	529 414,00
198	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27 500,00	55 000,00
199	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35 335 000,00	3 186 000,00
201	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	121 948,38	1 400 002,87
207	Бараа үйлчилгээний бусад зардал	61 297 297,82	8 783 249 084,21
208	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8 729 892 265,21
209	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61 297 297,82	53 356 819,00
249	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(1 023 177 486,77)	(9 488 829 693,41)
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	4 611 915 818,80	625 161 472,46
260	Гадаад валютын ханшийн зөрүү	4 611 915 818,80	625 161 472,46
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1 005 799 280,85	1 138 409 237,65
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1 005 799 280,85	1 138 409 237,65
263	Дотоод эх үүсвэрээр	1 005 799 280,85	1 138 409 237,65
267	Бусад хөрөнгө	238 292 950,00	-
276	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	767 506 330,85	1 138 409 237,65
279	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	3 606 116 537,95	(513 247 765,19)
280	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2 582 939 051,18	(10 002 077 458,60)
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16 424 908 903,88	19 007 847 955,06
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19 007 847 955,06	9 005 770 496,46



3.4 Аудит хийгдсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл					(4,700,608,124.82)	(4,700,608,124.82)
3	Залруулсан үлдэгдэл					(4,700,608,124.82)	(4,700,608,124.82)
4	Бусад дэлгэрэнгүй орлого						
5	Өмчид гаргасан өөрчлөлт						
6	Зарласан ногдол ашиг						
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(95489577757.85)	(95489577757.85)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
9	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл					(10,190,185,882.67)	(10,190,185,882.67)
11	Залруулсан үлдэгдэл						
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(2,507,647,196.72)	(2,507,647,196.72)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
17	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл					(12,697,833,079.39)	(12,697,833,079.39)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.5 Аудит хийгдсэн Зардлын гүйцэтгэлийн тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19 007 847 955,06		
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18 062 579 880,00	9 529 708 171,56	8 532 871 708,44	47,2
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	17 992 579 880,00	9 529 708 171,56	8 462 871 708,44	47,0
4	Бараа, үйлчилгээний зардал	17 992 579 880,00	9 529 708 171,56	8 462 871 708,44	47,0
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	936 889 320,00	440 965 211,40	495 924 108,60	52,9
6	Үндсэн цалин	827 769 320,00	425 605 211,40	402 164 108,60	48,6
9	Урамшуулал	56 320 000,00	-	56 320 000,00	100,0
10	Гэрээт ажлын хөлс	52 800 000,00	15 360 000,00	37 440 000,00	70,9
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102 952 224,00	48 364 107,05	54 588 116,95	53,0
12	Тэтгэврийн даатгал	65 515 052,00	31 030 784,89	34 484 267,11	52,6
14	Тэтгэмжийн даатгал	9 359 296,00	4 432 969,27	4 926 326,73	52,6
15	ҮОМШӨ ний даатгал	7 487 432,00	3 525 255,41	3 962 176,59	52,9
16	Ажилгүйдлийн даатгал	1 871 864,00	824 354,32	1 047 509,68	56,0
17	Эрүүл мэндийн даатгал	18 718 580,00	8 550 743,16	10 167 836,84	54,3
18	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126 672 000,00	120 609 067,38	6 062 932,62	4,8
19	Гэрэл цахилгаан	3 000 000,00	1 851 316,10	1 148 683,90	38,3
20	Түлш, халаалт	3 700 000,00	2 221 938,20	1 478 061,80	39,9
21	Цэвэр, бохир ус	1 100 000,00	913 273,08	186 726,92	17,0
22	Байрны түрээс	118 872 000,00	115 622 540,00	3 249 460,00	2,7
23	Хангамж, бараа материалын зардал	63 806 164,00	35 469 331,45	28 336 832,55	44,4
24	Бичиг хэрэг	7 674 150,00	6 093 958,00	1 580 192,00	20,6
25	Тээвэр (шатахуун)	28 740 298,00	14 025 855,00	14 714 443,00	51,2
26	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	17 191 716,00	9 895 133,45	7 296 582,55	42,4
29	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	6 600 000,00	2 166 025,00	4 433 975,00	67,2
30	Аж ахуйн материал худалдан авах зардал	3 600 000,00	3 288 360,00	311 640,00	8,7
35	Эд хогшил худалдан авах	13 320 000,00	12 983 983,20	336 016,80	2,5
39	Урсгал засвар	13 320 000,00	12 983 983,20	336 016,80	2,5
40	Томилолт, зочны зардал	183 131 875,00	68 673 420,00	114 458 455,00	62,5
41	Гадаад албан томилолт	125 309 875,00	54 525 891,00	70 783 984,00	56,5
42	Дотоод албан томилолт	45 232 000,00	11 627 780,00	33 604 220,00	74,3
43	Зочин төлөөлөгч хүлээн авах	12 590 000,00	2 519 749,00	10 070 251,00	80,0
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	84 640 420,00	19 393 966,87	65 246 453,13	77,1
45	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7 610 000,00	5 591 000,00	2 019 000,00	26,5
46	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	25 000 000,00	-	25 000 000,00	100,0



47	Даатгалын үйлчилгээ	15 653 320,00	8 965 050,00	6 688 270,00	42,7
48	Тээврийн хэрэгслийн татвар	609 100,00	529 414,00	79 686,00	13,1
49	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88 000,00	55 000,00	33 000,00	37,5
50	Мэдээллийн технологийн зардал	35 180 000,00	2 853 500,00	32 326 500,00	91,9
52	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500 000,00	1 400 002,87	(900 002,87)	-180,0
54	Бараа үйлчилгээний бусад зардал	16 481 167 877,00	8 783 249 084,21	7 697 918 792,79	46,7
55	Бараа үйлчилгээний бусад зардал	16 422 247 036,00	8 729 892 265,21	7 692 354 770,79	46,8
56	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58 920 841,00	53 356 819,00	5 564 022,00	9,4
84	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70 000 000,00	(0,00)	70 000 000,00	100,0
85	Дотоод эх үүсвэрээр	70 000 000,00	(0,00)	70 000 000,00	100,0
89	Бусад хөрөнгө	70 000 000,00	-	70 000 000,00	100,0
90	Гадаад валютын ханшийн гарз	-	(0,00)	0,00	
98	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	40 878 478,15	(40 878 478,15)	
111	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	40 878 478,15	(40 878 478,15)	
113	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	40 878 478,15	(40 878 478,15)	
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19 007 847 955,06		
129	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9 005 770 496,46		
130	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-		
131	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-		
134	АЖИЛЛАГСДЫН ТОО	25,00	21,00		
135	Удирдах ажилтан	5,00	4,00		
136	Гүйцэтгэх ажилтан	18,00	15,00		
137	Үйлчлэх ажилтан	2,00	2,00		